



ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ

Аль ч банкны харилцагч гар утсаараа төлбөр тооцоо хийдэг болоход нэг алхамаар ойртлоо

Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төв 2010 оны 6 дугаар сарын 16-ны өдөр /цаашид “ҮЦГТ”/ бүх карт гаргагч банктай хамтран “Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ”-г байгуулж, карт эзэмшигчид аль ч банкаар үйлчлүүлэх боломжийг нээж өгсөн нь бэлэн бус төлбөр тооцоог дэмжих, тэр дундаа төлбөрийн картын үйлчилгээг хөгжүүлэх хөдөлгөгч хүч болсон билээ. Үүнийг төлбөрийн картын хэрэглээний жил бүр өсөн нэмэгдэж буй тоон үзүүлэлтээс харж болох юм. Байгуулагдаад жил гаруй хугацаа өнгөрч байгаа боловч нэгдсэн сүлжээгээр 2011 оны эцсийн байдлаар нийт 254 тэрбум төгрөгийн дүнтэй 5,5 сая ширхэг банк хоорондын картын гүйлгээ дамжин боловсруулагдсан байна. Түүнчлэн нийт системээр 2011 оны эцсийн байдлаар 2,2 сая карт эзэмшигчийн 3,6 их наяд төгрөгийн 44,8 сая ширхэг гүйлгээ хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 65,8 хувь буюу 17,9 сая ширхэгээр нэмэгдсэн байна.

“Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ” нь картын хэрэглээ ийнхүү өсөн нэмэгдэх хөшүүрэг болсон төдийгүй цаашид төлбөр тооцооны системийг шат дараатай хөгжүүлэх бодлогыг тодорхойлж өгсөн юм. Иймээс Монголбанк банкуудтай хамтран картын үйлчилгээг иргэдэд илүү хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх бодлогын хүрээнд хийж буй томоохон төлөвлөгөөт ажлуудын нэг нь үндэсний брэнд картыг гаргах, нийтийн хүртээл болгох ажил болж байна. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 553 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан “Төлбөрийн картын журам”-д үндэсний брэнд картын нэр, лого загварын стандартыг тусгасан нь тус картыг гаргах хууль эрх зүйн үндсийг тавьж өгсөн.

Харин энэхүү үндэсний төлбөрийн картыг гаргагч анхны банк нь Худалдаа хөгжлийн банк болж байгаа бөгөөд албан ёсны нээлтээ удахгүй хийхээр төлөвлөж байна. Одоогийн байдлаар тус банкнаас гадна хэд хэдэн банк “F карт” төлбөрийн картыг дотооддоо гаргах зөвшөөрлийг Монголбанкнаас аваад байна. Ийнхүү Монголчууд бусад улс орны нэр, лого бүхий Виза, Мастер картны оронд Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийг бэлгэдэн нэршсэн “F карт” хэмээх төлбөрийн картыг хэрэглэж эхэллээ. Карт эзэмшигчид эхний ээлжинд тус төлбөрийн картаар дотооддоо гүйлгээ хийх бөгөөд цаашид олон улсын хэмжээнд хэрэглэх боломжтой болох юм. “F карт” төлбөрийн карт нь карт хэрэглэгчдэд үндэснийхээ үзлийг дээдлэх, бахархах сэтгэгдлийг төрүүлж, өөрсдийгөө гадныханд сурталчлан таниулах том хэрэгсэл болох төдийгүй Монгол Улсын иргэдийн төлбөрийн картаар үйлчлүүлсэн төлбөр тооцоо, мөнгөн урсгал болон банкуудын гадаад руу чиглэсэн их хэмжээний хөрөнгийг дотооддоо хадгалах зэрэг эдийн засгийн ихээхэн үр ашиг авчрах билээ.

Цаашид Монголбанк үндэсний “F карт” төлбөрийн карт дээр тулгуурлан Төрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад карт уншигч ПОС терминал байршуулах замаар төрийн үйлчилгээг иргэдэд зардал чирэгдэлгүй хүртээмжтэй хүргэх, гар утастай холбох зэрэг өргөн цар хүрээтэй ажлуудыг хийхээр төлөвлөөд байна.